

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2023/43-2-ШТА-ГА

**ДҮГНЭЛТ: ХАЙГУУЛ ХИЙСЭН ТАЛБАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Даланзадгад хот 2023 он



Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	2
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	2
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ	3-4
БҮЛЭГ 1. Хайгуулын нөхөн сэргээлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна	5-8
1.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сумын Засаг дарга санал оруулдаггүй байна	5-7
1.2. Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 29.0 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.....	7-8
БҮЛЭГ 2. Барьцаа хөрөнгийн тусгай данснаас 47.2 сая төгрөг зориулалт бусаар зарцуулсан байна	9-11
2.1 Төвлөрүүлсэн хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулаагүй байна.....	9-10
2.2 Сумдын Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	10-11
ДҮГНЭЛТ	12
ЗӨВЛӨМЖ	13
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
ААН	Аж ахуй нэгж

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт-1	Сумдад олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН
Хүснэгт-2	Барьцаа хөрөнгийг дутуу төвлөрүүлсэн хуулийн этгээдийн жагсаалт
Хүснэгт-2	Хөрөнгийн зарцуулалтын судалгаа (2020-2022 он
Дүрслэл-1	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн газар зүйн байрлал (2022 оны байдлаар)
Дүрслэл-2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, талбайн хэмжээ
Дүрслэл-3	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн БОХТ-ний батлагдсан маягт, түүнийг өөрчилсөн байдал
Дүрслэл-4	БОМТ батлуулсан байдал
Дүрслэл -5	Санал асуулгын үр дүн

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.
Аудитын зорилго	Уул уурхайн нөхөн сэргээлтийн үр дүнд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн нөхөн сэргээлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалттай эсэх; - Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн гүйцэтгэсэн нөхөн сэргээлт үр дүнтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Өмнөговь аймгийн хэмжээнд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн 2020-2022 оны үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн биелэлт, төрийн байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, ажлын баримт материалыг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитын гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухай асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитад ашигласан хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд	Дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: • Ашигт малтмалын тухай хууль (2006 он) • Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012 он) • Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал (2015 он) • Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам (2014 он) • Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам (2019 он) • Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд


Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн	Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Т.Хишигбат нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	БОАЖ-ын газар болон сумын байгаль орчны мэргэжилтнүүдийн ажлын чиг үүргийн давхардал, тэдгээрийн ажлын уялдаа, зохион байгуулалтгүй байдал, зарим мэргэжилтэн солигдсон шалтгаанаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн баримт материалын бүрдэл дутуу, судалгаа, тайлан, тоон мэдээлэл зөрүүтэй ирүүлж байсан.

БҮЛЭГ 1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сумын Засаг дарга санал оруулдаггүй байна

1.1 Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар 334.4 мянган га талбайд 49 ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртгэлтэй байгаа нь нутаг дэвсгэрийн 2.0 хувийг эзэлж байна.

Дүрслэл 1. Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн газар зүйн байрлал (2022 оны байдлаар)




1.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид аймгийн 15 сумаас 12 суманд үйл ажиллагаагаа явуулж байна. Булган, Даланзадгад, Сэврэй сумдын нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна.

Хүснэгт 1. Сумдад олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН

№	Сумын нэрс	Сумын газар нутгийн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	
			ААН-н тоо	Талбайн хэмжээ /га/
1	Баяндалай	1,075,100.00	3	20059.43
2	Баян-Овоо	1,130,000.00	7	21869.58
3	Гурвантэс	2,796,700.00	1	2883.34
4	Мандал-Овоо	643,300.00	2	9229.56
5	Манлай	1,241,800.00	5	46719.04
6	Ноён	1,055,000.00	3	10522.04
7	Номгон	1,946,800.00	2	13008.74
8	Ханбогд	1,515,100.00	8	57837.73
9	Ханхонгор	993,100.00	3	12025.06
10	Хүрмэн	1,239,300.00	3	4776.31
11	Цогт-Овоо	652,600.00	10	61242.27
12	Цогтцэций	724,600.00	2	23956.48

1.3 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо жил бүр буурч байгаа нь ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1¹, 56.1.2² дахь заалтын дагуу цуцлагдсантай холбоотой байна.


Дүрслэл 2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, талбайн хэмжээ



1.4 Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1³ дахь заалт, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.1⁴ дахь заалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулахаар заасан байдаг.

1.5 Гэвч хууль журамд заасан батлагдсан маягтыг өөрчилж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтэн нар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянаж, зөвшөөрөл олгож баталгаажуулсан байна.

1.6 Дүрслэл 3. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн БОХТ-ний батлагдсан маягт, түүнийг өөрчилсөн байдал



¹ тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 7.2, 31 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангахгүй болсон

² тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн 34.7-д заасан хугацаанд нь бүрэн төлөөгүй

³ Тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах


⁴ 2.1. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

1.7 Энэ нь сумдын Засаг дарга байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд санал оруулах боломжийг хязгаарлах, төрийн байгууллагын шат дамжлагыг нэмэгдүүлэх сөрөг үр дагаврыг буй болгож байна.

1.8 Аймгийн хэмжээнд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 167 (давхардсан тоогоор) ААН байгаагаас 94 (давхардсан тоогоор) хуулийн этгээдийн баримт материалыг ирүүлсэн. Үүнээс БОМТ-г 18 ААН батлуулаагүй байна.

1.9 Эдгээрээс 16 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Дүрслэл 4. БОМТ батлуулсан байдал



1.10 Дээрх дүрслэлээс харахад БОМТ батлуулаагүй үйл ажиллагаа явуулж байгаа нь нөхөн сэргээлт хийгдэхгүй байх, төсвийн орлого дутуу төвлөрх эрсдлийг дагуулж байна.

1.11 Мөн Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн БОМТ-г байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч архивын хадгаламжийн нэгж үүсгээгүй зөрчил 11 суманд илэрсэн. (Хавсралт судалгаа №1)

1.12 Энэ нь баримт бичгийн үнэн зөв, иж бүрэн байх шаардлага, хайгуулын үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулах сөрөг үр дагавартай байна.

1.13 Иймд байгаль орчны нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг архивын нэгж үүсгэж байх албан шаардлагыг сумын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 29.0 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна

1.14 Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны тушаалаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг баталсан. Энэхүү журамд заасан тусгай данс нь сумдад байдаггүй бөгөөд барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж байна.

1.15 Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9⁵, Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1⁶, 38.1.8⁷ дахь заалт, Байгаль орчны

⁵ Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана

⁶ Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээн

⁷ Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх

менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.3⁸ -д заасан дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө болох 102.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээр байна.

1.16 Гэвч сумдын барьцаа хөрөнгийн тусгай дансанд 73.1 сая төгрөг төвлөрч 26 (давхардсан тоогоор) хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 29.0 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Барьцаа хөрөнгийг дутуу төвлөрүүлсэн хуулийн этгээдийн жагсаалт

№	Огноо	Сумын нэрс	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэрс (ХХК)	Барьцаа хөрөнгийг дутуу төвлөрүүлсэн дүн /сая төгрөг/
1	2020	Манлай	Кроссфор ворлд майнинг лимитед	0.2
2		Номгон	БЭТТА	0.5
3		Хүрмэн	Азаргын гол чонот	1.0
4	2021	Баян-Овоо	Хардэл бэйс	0.8
5		Манлай	Эрдэнэс силвер ресурс	5.2
6		Ноён	Динг шэнг шин	0.5
7		Ханхонгор	Ай ти икс	0.5
8		Ханхонгор	Дэ-Юан	0.2
9		Цогт-Овоо	Геоган дөл сервис	0.2
10		Баяндалай	Цайна инвестмент монголиа	1.0
11		Баян-Овоо	Азийн хөх тэнгэр групп	2.5
12	2022	Баян-Овоо	Хардэл бэйс	4.5
13		Баян-Овоо	Шижир баялаг	1.5
14		Баян-Овоо	Ямаат борзон	1.5
15		Гурвантэс	Азаргын гол чонот	1.0
16		Манлай	Голден гроуз айбекс	1.0
17		Манлай	Голденхилл	0.5
18		Манлай	Кроссфор ворлд майнинг лимитед	1.0
19		Ноён	Динг шэнг шин	0.1
20		Номгон	Баян фү жин	1.5
21		Ханбогд	Херуга-Эксплорэйшн	2.2
22		Ханхонгор	Ай ти икс	0.2
23		Цогт-Овоо	Азийн эртний зулай	0.5
24		Цогт-Овоо	Геоган дөл сервис	0.2
25		Цогт-Овоо	Рейр Метал Майнинг	0.5
26		Манлай	Кроссфор ворлд майнинг лимитед	0.2
НИЙТ ДҮН				29.0


1.17 Дээрх байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

⁸ Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлыг бүрэн тооцож түүний 50 хувийн барьцааг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч сумын байгаль орчны барьцаа хөрөнгийн, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд тус тус байршуулна.

БҮЛЭГ 2. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ТУСГАЙ ДАНСНААС 47.2 САЯ ТӨГРӨГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА

Төвлөрүүлсэн хөрөнгийг журамд заасны дагуу зарцуулаагүй байна.

2.1 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 2020-2022 онд 151 (давхардсан тоогоор) хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж, 16 (давхардсан тоогоор) ААН үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнд:



2.2 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийг Хүрмэн, Мандал-Овоо сумын байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид шинээр томилогдсон гэх шалтгаанаар мэдэхгүй байх зөрчил аудитын явцад илэрсэн.

2.3 Энэ нь төрийн захиргааны байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, ажлын уялдаа хангалтгүй байгааг харуулж байна.

2.4 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн сумдын барьцаа хөрөнгийн тусгай дансанд 2020-2022 онд 73.1 сая төгрөг төвлөрч, 50.4 сая төгрөг зарцуулсан байна.

2.5 Үүнээс 47.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.6 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төвлөрүүлсэн барьцаа хөрөнгийн тусгай данснаас зориулалт бусаар зарцуулсан байдлыг он тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Хөрөнгийн зарцуулалтын судалгаа (2020-2022 он)

№	Он	Сумын нэр	Зарцуулалт	Дүн /сая төгрөг/
1	2020	Баяндалай	Шатахуун, ариутгалын бодис, нохой устгал, хайлаас худалдан авах	1.7
2		Баян-Овоо	Шаланк, хоол, модны нүх ухсан, усалгаа хийсэн ажлын хөлс, шатахуун, бээлий, цоожны үнэ	5.8
3		Цогт-Овоо	Ялзмаг, тоолуур, цахилгааны утас үнэ, шатахууны үнэ	1.0
4		Цогтцэций	Хог цэвэрлэгээ цалин, хогийн уут, бээлий, хоол, бараа, цэвэрлэгээний материалын үнэ	3.8
5	2021	Баяндалай	Шланкны үнэ	1.0
6		Номгон	Малчдаа дэмжье аяны зардал, ан амьтан био техникийн арга хэмжээний зардал	1.5
7		Ноён	Цагаан өвөлжөө барьцаа хөрөнгө чөлөөлсөн (хүлээн авагч өөр нэртэй)	17.0

8		Цогтцэций	Мод тарих ажлын хөлс, ойжуулалтын шатахуун, ажлын хөлс, бараа, тоолуур, насосын үнэ	4.7
9		Баяндалай	Барьцааны буцаалт (хувь хүний данс)	0.4
10	2022	Номгон	Малчдаа дэмжье аяны зардал, Барьцааны буцаан олголт (хүлээн авагч өөр нэртэй)	7.5
11		Ноён	Ойжуулалтын шатахуун, бээлий, уут, хог цэвэрлэгээний цэвэр ус, бараа, ажлын хөлс, шатахууны үнэ	2.8
Нийт				47.2

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

2.7 Дээрх зарцуулалт нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 5.5⁹ дахь заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Сумдын Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.8 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан Байгаль орчны менежментийг төлөвлөгөө боловсруулах, хянаж батлах, тайлагнах журамд заасан загвар, маягтын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргасан байна.

2.9 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2020-2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг ирүүлэх ёстой 167 ААН байгаагаас аудитаар 53 (давхардсан тоогоор) ААН биелэлтийн тайланг ирүүлж, 18 (давхардсан тоогоор) ААН тайлан ирүүлээгүй, бусад 96 (давхардсан тоогоор) ААН-ын биелэлт тайлан сумын ЗДТГ болон аймгийн Байгаль орчны газарт ирүүлсэн нь баримтаар нотлогдохгүй байна.

2.10 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн тусгай дансанд байршуулах мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг төрийн сангийн мэргэжилтэн жилийн эцэст сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.

2.11 Энэ нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмын 4.1¹⁰ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь тус дансанд баталгааны 50 хувийн мөнгөн хөрөнгө орсон эсэхэд тавих хяналтыг сулруулж байна.

2.12 Мөн сумын ЗДТГ-т ирүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг үнэлж дүгнэх хуудсаар баталгаажуулаагүй байна.

2.13 Тус зөрчилд сумдын Засаг даргад холбогдох албан тушаалтнуудын хууль, эрх зүйн мэдлэгийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

2.14 Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй менежментийн төлөвлөгөө батлуулсан 76 ААН цар тахлаас шалтгаалан техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай хайгуулын ажил гүйцэтгээгүй байна.

⁹ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

¹⁰ Сум, дүүргийн Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сум, дүүргийн төрийн сангийн төлөөлөгч жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ


2.15 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хайгуулын талбайд геологийн нарийвчилсан зураглалын ажил, хөрс, чулуунаас дээж авах, цэглэн сорьцлолт, талбайн геохимийн сорьцлолт, соронзон хайгуул 2 хэмжээст загварын дахин боловсруулалт, соронзон хайгуулын урвуу бодолтын 3 хэмжээст загварчлал, лабораторийн шинжилгээ болон суурин боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2.16 Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн болон байгаль хамгаалагчид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн ирүүлсэн байгаль орчныг хамгаалах, менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт хийгээгүй байна.


2.17 Аудитын явцад дараах 2 асуултаар 6 сумын 40 иргэд, малчдаас санал асуулга авахад хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар мэдлэг, мэдээллээр хангагдахгүй байгааг харуулж байна. Үүнд:

Дүрслэл 5. Санал асуулгын үр дүн

1. Танай сумын нутаг дэвсгэрт хэдэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байдаг талаар мэдэх үү?



2. Тухайн аж ахуйн нэгж хэдий хэмжээний нутаг дэвсгэрт хайгуул хийж байгаа талаар мэдэх үү?



2.18 Иймд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн талаар мэдээллийг Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2¹¹, 12.2.2¹² дахь заалтыг хэрэгжүүлэн, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах талаар сумдын Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.

¹¹ Ашигт малтмалын асуудлаар сумын Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

¹² Харьяалах нутаг дэвсгэрт эрдэс баялгийн салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийн талаар жил бүр олон нийтэд мэдээлэх;

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Аймгийн хэмжээнд 334.4 мянган га талбайд 49 ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртгэлтэй байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 2.0 хувийг эзэлж байна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс 16 үйл ажиллагаа явуулсан байна.
- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс нийт 102.1 сая төвлөрүүлэхээс 73.1 сая төгрөг төвлөрч 29.0 сая төгрөг дутуу төвлөрсөн байна.
- Барьцаа хөрөнгийн тусгай данснаас 50.4 сая төгрөг зарцуулснаас 47.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Хайгуул хийсэн талбайн нөхөн сэргээлтэд орхигдсон талбай байгаа эсэхэд хяналт хийгээгүй байна.
- Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчид хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.
- Иргэд, малчдид хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар мэдлэг, мэдээллээр хангагддаггүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Р.СЭДДОРЖ ТАНАА

1. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд, сумдын мэдээлэл солилцох, ажлын уялдааг сайжруулах, мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх талаар ажил зохион байгуулах.

СУМДЫН ИТХ-ЫН ДАРГА НАРТ:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж, мэдээллийн сан үүсгэж байх,

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид тавих хяналтыг сайжруулан, үр дүнг тооцох,
2. Сумын иргэд, олон нийтэд нутаг дэвсгэрт эрдэс баялгийн салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийн талаар жил бүр олон нийтэд мэдээлж байх

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/23

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байгаль орчин, уул уурхайн нөхөн сэргээлтийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Н.Энхбат), Засаг дарга (Р.Сэддорж), сумдын Засаг дарга нарт даалгасугай.
4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Т.Хонгорзул)-д даалгасугай.
5. Аудитын ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР

D:\2023 Он\Бичиг Хэрэг\Т.Ш.С.А.О. 016010748